



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/473

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.17 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.8, 25.9.1 дэх заалт, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-ын 2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл анх удаа олгох гадаадын 4 эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /П.Эрхэмбаяр/-д даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141222251

Эрүүл мэндийн сайдын 2022
оны 09 дүгээр сарын 23 өдрийн
А/423...дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ АНХ УДАА ОЛГОХ
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажиллах эрүүл мэндийн байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1	Якимов Юрий Алексеевич	ОХУ	Улсын Гуравдугаар төв эмнэлэг	-	ГЭ0002633	Мэс Засал судлал	Эмчлэх	/2022.09.27-2022.09.29/ 3 хоног
2	Суфианов Альберт Акрамович	ОХУ	Улсын Гуравдугаар төв эмнэлэг	-	ГЭ0002634	Мэс Засал судлал	Эмчлэх	/2022.09.27-2022.09.29/ 3 хоног
3	Тан Гайк Имм	Малайз	АШУУИС-ийн Монгол Япон эмнэлэг	-	ГЭ0002635	Эмэгтэйчүүдийн өвчин судлал	Эмчлэх	/2022.09.27-2022.09.29/ 3 хоног
4	Эн Жи Пох Иин	Малайз	АШУУИС-ийн Монгол Япон эмнэлэг	-	ГЭ0002636	Эмэгтэйчүүдийн өвчин судлал	Эмчлэх	/2022.09.27-2022.09.29/ 3 хоног